199 47

101

Улсын төлбөлгөөний комисын 1946 оны 2 дугаар сарын 1 ны өдрийн 6 дугаар хурлын тогтоол:

Гадаад явдлын яамны барилгануудыг барьж дуусгах тухай.

Нэг. гадаад явдлын яамны байшин нэг, зочидын байрь гурав, эдгээр дөрвөн барилгыг барьж гүйцэтгэхийг олзлогдсон цэргийн хэрэг эрхлэх газрын дарга нөхөр СОСОРВАРАМД үүрэг болгосугай.

Хоёр. дээр дурьдсан барилгануудыг 1946 оны барилгын төлбөлгөөний түрүүн ээлжинд оруулж барьж гүйцэтгэвээс зохих бөгөөд түүний дотроос нүхтийн амны ба хотын зочдын байрыг 7 дугаар сарын 1 ны наана дуусагасугай.

Гурав. Энэ барилгыг гүйцэтгэх тухай хоорондоо хоёрдугаар сарын 13 ны дотор гэрээ байгуулбал зохихыг Гадаад явдлын яам ба олзлогдсон цэргийн хэрэг эрхлэх газарт Даалгасугай.

Дөрөв. Энэ тогтоолын биелэлт ба барилгын явцыг техникийн талаар үргэлж шалгаж байхыг тус комисын их барилгын хэлтэсд үүрэг болгосугай.

200.
45

Улсын төлбөлгөөний

комисын дарга ( ЦЭДЭНБАЛ )

Орлогч дарга ( ЖАГВАРАЛ )

Гишүүд ( ЛУВСАН )

( ДАМВА )

( ЛАМЖАВ )

( БЯМБА )

( ОСОР )